

АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН
Т.ДЭЛГЭРМААГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Гүйцэтгэлийн түвшин							
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Үнэлгээний үр дүнг дээшлүүлнэ.	
						6	7
Зорилт 1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, Политехник коллежийн сурагчдын сурлагын амжилт, гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг дээшлүүлнэ.							
	1	2	3	4	5	6	7
1.1	Намхайн Төмөрхүү агсаны нэрэмжит Физикийн улсын олимпиадыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	1	1	Нэг үеийн сурагчдын дундах өрсөлдөөнийг ихэсгэх, бүс нутгийн Физикийн шинжлэх ухааныг сонирхох өсвөр үеийн хүүхэд залуучуудын тоог нэмэгдүүлэх зорилгоор Улсын Физикийн ХХХVІ олимпиадыг аймгийн Боловсролын газартай хамтран 04 дүгээр сарын 05-08-ны өдрүүдэд зохион байгуулж, 21 аймаг, 9 дүүргийн суралцагчид оролцож, 9 дүгээр ангийн төрөлд 50 сурагч, 12 дугаар ангийн төрөлд 55 сурагч, багшийн төрөлд 49 багш, нийт 154 оролцогч мэдлэг, чадвар, оюун ухаанаа уралдуулсан. Олимпиадын 9 дүгээр ангийн ангилалд ерөнхий боловсролын Мэргэд сургуулийн сурагч О.Осоржин хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлээ. Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газраас физикийн олимпиадыг зохион байгуулах зардалд 50 сая төгрөгийг зарцуулсан.	2025.01.02 2025.06.10	100
1.2	Багш солилцооны хөтөлбөрийг зохион байгуулж, шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.	Багш солилцоо хөтөлбөрт хамрагдсан багш нарын тоогоор	15	20	Багшийн тасралтгүй хөгжил, сургууль хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, сайн туршлагаа солилцон хамтдаа хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад багш солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. 2025 оны 11 сарын байдлаар ерөнхий боловсролын сургуулиуд 22, сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд 20 багшийг "Багш солилцоо" хөтөлбөрийн хүрээнд шинэ зуун бүсийн сургуулиуд болон Хархорин, Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий сумдын ерөнхий боловсролын	2025.01.02 2025.12.01	100

				сургуулиудтай харилцан туршлага судлуулснаар багшийн мэргэжлийн ур чадвар, хөгжил, оролцоо сайжирч, сайн туршлага арга зүйг сургалт үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Арвайхээр сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн "Соёмбын залуус" клубийн багш нарын санаачилгаар "Шинэ зуун бүс"-ийн боловсролын байгууллагын залуу багш, ажилчдын чуулганыг зохион байгуулсан. Чуулганд оролцож буй багш, ажилчид "Залуусын нийгмийн баталгаа", "Залуусын ажлын байран дахь хөгжил", "Багшийн ажлын үнэлэмж, нийгэм дэх байр суурь", "Багшийн сэтгэлзүй" зэрэг сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулж, тулгамдаж буй асуудлаа тодорхойлж, хамтын ажиллагаагаа нэгтгэн, харилцан туршлага солилцлоо. Чуулганд ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон Политехникийн коллежийн 300 гаруй багш, ажилчид хамрагдлаа. Дээрх арга хэмжээг зохион байгуулах зардалд Засаг даргын Тамгын газраас 4,0 сая төгрөгийг зарцуулсан.		
1.3	Харьяа ерөнхий боловсролын сургуулиудад зөвлөн ажлыг зохион байгуулна	Зөвлөн тусалсан байгууллагын тоогоор	6	Ерөнхий боловсролын сургуулиудын үйл ажиллагаа, сургуулийн орчин нөхцөлтэй танилцаж, албан хаагчдын санал хүсэлт, тулгамдаж буй асуудлыг сонсож, цаашдын үйл ажиллагаандаа тусгах зорилгоор Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг ерөнхий боловсролын 6 сургуулийн 300 орчим багш ажилчидтай уулзаж санал хүсэлтийг сонслоо. Багш нарын зүгээс гарсан хамран сургах тойрогт түр оршин суугчдын хүүхдүүдийг хамруулахгүй байх, гадна авто зогсоол, камержуулалт, сурагчдын аюулгүй байдлыг бүрдүүлж сургуулийн автобус явуулах, сургалтын орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, сургуулийн ойр орчмын түргэн хоолны газруудын стандарт, хүнсний аюулгүй байддалд хяналт тавих зэрэг олон саналыг хүлээн авч, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар шийдвэрлүүлэх, үе шаттайгаар	2025.01.02 2025.12.01	100

					шийдвэрлэх талаар анхаарч ажиллахаар болсон. Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын 2025 оны улсын үзлэгийн урьдчилсан үзлэгийг 2025 оны 09 дүгээр сарын 20-23-ны өдрүүдэд зохион байгуулж, 25 байгууллага хамрагдсан, Урьдчилсан үзлэгээр төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, албан хэрэг хөтлөлт, байгууллагын архивын үйл ажиллагаа, өмнөх үзлэгийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэрэг 4 үндсэн агуулгаар нийт 25 байгууллагад удирдамж, шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээ хийж, арга зүйн зөвлөмжийг өгч ажилласан.		
Зорилт 2. Боловсролын байгууллагын барилга, байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан, тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлж, цэцэрлэг, сургуулийн анги, бүлэг дүүргэлтийг багасгана.							
2.1	Ерөнхий боловсролын сургууль, өмнөх боловсролын байгууллагын барилгын гадна болон дотор орчны хүртээмжийн үнэлгээ хийж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Хүртээмжтэй болсон байгууллагын тоогоор	-	10	Арвайхээр сумын хэмжээнд ерөнхий боловсролын 6 сургууль, 15 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаагаас ерөнхий боловсролын 6 сургууль, 1, 3, 4, 9, 12, 13, 15 дугаар цэцэрлэгийн байгууллагын гаднах налуу зам стандартын шаардлага хангасан. 1, 4, 9, 13, 15 дугаар цэцэрлэгүүд хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжийг хангасан 00, бариултай болж, дотор хүртээмжийг нэмэгдүүлсэн. 13 байгууллага гадна орчин, 5 байгууллага дотор орчны хүртээмжийг нэмэгдүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчин бүрдүүлсэн. 1, 15 дугаар цэцэрлэгүүдийг ашиглалтад ороход хүртээмжийн үнэлгээ хийж, улсын комисс хүлээн авсан.	2025.01.02 2025.12.01	75
2.2	Суралцагсдын дундах үе тэнгийн дээрэлхэлт, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх хэмжээг зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	2	4	Ерөнхий боловсролын 6 сургуулийн хүүхдийн өөрөө удирдах байгууллагуудын дунд хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэх, ахуйн осол гэмтэл, орчны аюулгүй байдлыг хангах зөв зохистой хооллолт, электрон тамхины хор нөлөө, үе тэнгийн дээрэлхэлт хотын соёлыг төлөвшүүлэх 2 сарын аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд сургуулиуд "Хамтдаа хөгжье", "Багш үлгэрлэе", "Аз жаргалыг түгээе", "Цахим орчинд зэрэг зүйлийг түгээе" зэрэг нөлөөллийн ажлыг зохион	2025.01.02 2025.12.01	100

				байгуулж, давхардсан тоогоор 3200 гаруй сурагчид оролцсон. "Бидний манлайлаг-Ирээдүйн соёлд" хүүхдийн чуулганыг ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн Хүүхдийн нэгдсэн зөвлөлтэй хамтран зохион байгуулсан. Чуулганд ерөнхий боловсролын 6 сургууль, Политехник коллежийн 250 сурагч оролцож, өөрсдийн дуу хоолой, үзэл бодлоо хуваалцсан. Чуулганд оролцогчид хүүхдийн эрх, хотын соёл, хариуцлагатай хүүхэд байх, сургуулийн орчин дахь дээрэлхэлтийн талаар чөлөөтэй ярилцан, санал хүсэлтээ шийдвэрлэх түвшний хүмүүст хүргэсэн. Чуулганаас "Хотын соёлыг эрхэмлэе!, Хариуцлагатай хүүхэд байе!", Сургуулийн орчинд дээрэлхэлтийг таслан зогсооё!" гэсэн уриаллыг үе тэнгийн хүүхдүүдээ уриалсан. Хүүхдүүдийн үзэл бодол, дуу хоолойг шийдвэр гаргах түвшний хүмүүст хүргэх, мэдээлэл авах, эвлэлдэн нэгдэх, эрхээ эдлэх боломжийг хангах, тэдний өмнө тулгамдаж буй асуудлыг сонсож, цаашдын үйл ажиллагаандаа тусгах зорилгоор "Хүүхдээ сонсох өдөр"-ийг зохион байгуулж, ерөнхий боловсролын 6 сургуулийн 600 гаруй хүүхэдтэй уулзаж, санал хүсэлтийг хүлээн авсан. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралтай хамтран "Хотын соёл-Хариуцлагатай иргэн" зорилгот жилийн хүрээнд "Зүрх сэтгэлийн боловсрол" сэдэвт харилцаа хандлагын сургалтыг ерөнхий боловсролын 6 сургуулийн ахлах ангийн 400 сурагчид зохион байгуулсан.			
2.3 хүүхдийн хөгжлийг арга хэрэгжүүлж, насны яслийн үйлчилгээний хувилбарыг дэмжих ажиллана.	Бага насны (0-5 нас) хүүхдийн хөгжлийг арга хэрэгжүүлж, насны яслийн үйлчилгээний хувилбарыг дэмжих ажиллана.	Дэмжлэг үзүүлсэн мөнгөн дүн	3,0 сая	3,5 сая	Засгийн газрын 2020 оны "Яслийн үйлчилгээний тухай" 223 дугаар тогтоолын 1 дэх заалтаар яслийн үйлчилгээг 12 ба түүнээс дээш бүлэгтэй хүүхдийн цэцэрлэгийг түшиглэн явуулахаар заасан ба сумын хэмжээнд 12 бүлэгтэй цэцэрлэг байхгүй тул яслийн үйлчилгээ явуулах хэрэгцээ шаардлага байхгүй. Сумын хэмжээнд хувийн 3 цэцэрлэгт 125 хүүхэд хамрагдаж, үүнээс 35 хүүхэд нь 2 нас хүрээгүй хүүхдүүд байна. "Бидэнд хайрлагдах зүрх" хувийн цэцэрлэг нь 1,8-3 насны	2025.01.02 2025.12.01	100

				25 хүүхэдтэй холимог бүлэг хичээллүүлж байна. Тус цэцэрлэгийн чийрэгжүүлэлтийн өрөөг тохижуулахад 2.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн.		
--	--	--	--	--	--	--

Зорилт 3. “Хотын соёл хөтөлбөрийг хэрэгжүүлэх”

				Хотын соёл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар Засаг даргын зөвлөлийн хуралд тайлан хэлэлцүүлсэн. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудаас тайланг авч нэгтгэн дүгнэхэд “Хотын соёл” хөтөлбөр ерөнхий боловсролын сургууль, сургуулийн емнөх боловсролын байгууллагуудад харилцан адилгүй хэрэгжиж байна. Ерөнхий боловсролын сургуулийн заавал судлах судлагдахуун нь жилдээ судлах агуулгадаа тохирсон цагтай байдаг бөгөөд “Хотын соёл” хөтөлбөрийн агуулга нь нэмэлт дасгал, даалгавар төдийнөөр хягаарлагдаж байна. Хөтөлбөрийн хүрээнд гарын авлага, сурах бичиг, интерактив хичээл, контент зэрэг зориулан гаргасан хэрэглэгдэхүүн хомс байгаа нь сурагчдад хүртээмжгүй, үр дүн хүлээхэд асуудалтай байна. Цаашид “Хотын соёл” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр дүнд хүргэхийн тулд хөтөлбөрийг шинэчлэн батлуулахаар төлөвлөсөн. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд хотын соёл, иргэний хариуцлагын талаарх зөв ойлголт, төлөвшлийг бий болгох, бүтээлч сэтгэлгээ, зөв бичгийн болон өөрийн үзэл бодлоо илэрхийлэх үр чадварыг хөгжүүлэх, иргэний үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, нийгэмд зөрөг хандлага төлөвшүүлэх зорилгоор “Хотын соёл-Хариуцлагатай иргэн” сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг 2 насны ангиллаар зохион байгуулсан. Уралдаанд 8-9 дүгээр ангийн ангилалд 18, 10-12 дугаар ангийн ангилалд 22, нийт 40 эсээ ирсэн. Ангилал тус бүрд эхний 4 байрыг шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.		
3.1	“Хотын соёл” хөтөлбөрийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах	Зохион байгуулсан ажлын тоогоор	-	1	2025.01.02 2025.12.01	50

Зорилт 4. “Ахмад настнуудын эрэлт хэрэгцээнд суурилсан үйл ажиллагааг зохион байгуулж, нийтийн идэвх оролцоог нэмэгдүүлэх”

4.1	Сумын ахмадуудын нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэхэд ахмадын байгууллагуудтай хамтарч ажиллах	Зохихон байгуулсан арга хэмжээний тоогоор	2	2	Ахмад настнуудын хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, ардын уламжлалт соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх, ахмадуудын авьяас чадварыг хөгжүүлэх, тэдний уран бүтээлийг олон нийтэд алдаршуулах зорилгоор "Урлагийн наадам-2025" наадмын 1 дүгээр шатны шалгаруулалтыг 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр 13 багийн ахмадуудын дунд 7 төрлөөр зохион байгуулж, нийт 100 гаруй ахмадууд авьяас чадвараараа өрсөлдөж, 2 дугаар шатанд оролцох эрхээ авсан. Уянга суманд болсон төвийн бүсийн ахмадуудын "Урлагийн наадам-2025"-т Арвайхээр сумын 40 гаруй ахмадууд амжилттай оролцсон. Үндэсний хөгжим, ардын харилцаа дуу, эрэгтэй найрал дууны төрөлд 1 дүгээр байр, уртын дуу, бий биелгээний төрөлд 2 дугаар байр, уртын дуу, язгуур урлаг, хит дуу, ерөөл магтаал, эмэгтэй найрал дуу төрөлд 3 дугаар байранд шалгарч, аймгийн наадамд оролцох эрхийг авсан. Бүсийн тэмцээний шатналын зардалд Засаг даргын Тамгын газраас 1,5 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. Ахмадын баясах өдрийг Өлзийтийн 4 дүгээр багийн ахмадын зөвлөлийн хамтран зохион байгуулж, дээрх арга хэмжээг зохион байгуулах зардалд Засаг даргын Тамгын газраас 505,000 төгрөгийг зарцуулсан. Олон улсын ахмадын баярыг тохиолдуулан "Ахмадаа сонсьё" уулзалтыг 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулж, ахмадуудын дунд тулгамдаж буй асуудлыг сонслоо. Уулзалтад сумын Засаг дарга, аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Сайнжаргал нар оролцож, ахмадуудын санал хүсэлтийг сонсож, асуусан асуултуудад хариуллаа. Ахмадаа сонсьё уулзалт, арга хэмжээнд 112 ахмад оролцож, цаашид улирал тутам зохион байгуулж байхаар болсон. Аймгийн насан туршийн суралцахуйн төвтэй хамтран "Ахмадууд суралцаж байна" өдөрлөгийг 2025 оны 09 дүгээр сарын 17-нд зохион байгууллаа.	2025.01.02 2025.12.01	100
-----	---	---	---	---	---	--------------------------	-----

				Суралцагч иргэн, “Хотын соёл-Хариуцлагатай иргэн” зорилтот жилийн хүрээнд иргэн бүр насан туршдаа суралцах хандлагыг ахмад насныханд төлөвшүүлэх мөн эрүүл амьдралын хэв маягт уриалах зорилготойгоор зохион байгуулагдсан сургалт, өдөрлөгт 13 багийн 41 ахмад оролцоо. Дараах сургалт мэдээллийг хамрагч байгууллагуудтай хамтран хүргэсэн. -Ахмад нас ба танин мэдэхүйн хөгжил, Өндөр настны бие махбодын өөрчлөлт гэсэн сэдэвт сургалтыг Насан туршийн суралцахуйн төв -Биеийн тамир спортын газраас оролцогч нарт биеийн хөгжлийн индекс, таниаг аппаратаар бие махбодын дотоод үзүүлэлтийг хэмжих -Өвөрхангай аймгийн ахмадын хорооноос ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээ, ахмад настны хувилбарт үйлчилгээ -Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас нийгмийн халамжийн сангаас ахмад настнуудад олгож буй тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламж -Зөв цаг бүжгийн клубээс бүжгийн хөдөлгөөн зааж идэвхтэй амьдралын хэв маягт уриалан оролцсон. Мөн иогийн багш Д.Батгэрэл иогийн ач холбогдол идэвхтэй амьдралын хэв маягийн талаар мэдээлэл өгсөн. Аравдугаар багийн ахмадын төлөөлөл оролцогч нарт хийн дасгал зааж өгч хамтдаа дасгал хийсэн.			
4.2	Байгууллагын харьяалалтай ахмадуудыг хүлээн авч, санал хүсэлтийг сонсох, шийдвэрлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	2	2	Сар шинийн баяр, Ахмадын баярыг тохиолдуулан Засаг даргын Тамгын газарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг 2 удаа зохион байгуулаа. Нийт 34 ахмад настанд тус бүр гарын бэлэг гардуулж, хүлээн авч, хүндэтгэл үзүүлэн, ахмадуудынхаа санал хүсэлтийг сонслоо. Дээрх 2 удаагийн арга хэмжээг зохион байгуулахад Тамгын газраас 4.497.556 (дөрвөн сая дөрвөн зуун ерэн долгон мянга таван зуун тавин зургаа) төгрөгийг зарцуулсан.	2025.01.02 2025.12.01	100

Зорилт 5. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах”

Зорилт 5. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах”

5.1	Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, биелэлтийг бүтэн жилээр тайлангах, хурал болон удирдлагаас өгсөн даалгаврын биелэлтийг тайлангах	Тайлан мэдээний биелэлтийн хувиар	100	Байгууллага, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь тайлагнаж ажигласан байна	Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, Зорилтот жилийн ажлын төлөвлөгөө, Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгуудийн холбогдох заалтын тайланг холбогдох албан хаагчдад өгч хэвшсэн.	2025.01.02 2025.12.01	100
5.2	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	Ирсэн хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн хувь	100	100	Байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүнээр ажиглаж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ёс зүйн зөрчил гаргалгүй ажигласан. Байгууллагын ёс зүйн дэд хорооноос аймгийн Цагдаагийн газрын замын цагдаагийн тасагтай хамтран гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан таниулах сургалт зохион байгуулж, нийт алба хаагчид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх уриалгад нэгдсэн. Бүсчилсэн хөгжил, төрийн албаны манлайлал хангайн бүсийн төрийн албан хаагчдын чуулганд оролцож, төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ сургалт хэлэлцүүлэгт хамрагдсан.	2025.01.02 2025.12.01	100
5.3	Байгууллагаас зохион байгуулсан	Зохион байгуулсан	100		Байгууллагаас зохион байгуулсан нийтийг хамарсан арга хэмжээ, сургалтад бүрэн	2025.01.02 2025.12.01	100

нийтийг хамарсан арга хэмжээ, сургалтад бүрэн хамрагдах	сургалт арга хэмжээнд хамрагдалтын хувиар			хамрагдсан. Байгууллагын шуурхай хурал, байгууллагаас зохион байгуулсан сургалтуудад тухай бүр тогтмол хамрагдсан.			
Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт							
Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	Сумын хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах	Хүүхийн баярын арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах	-	-	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан сумын Хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээг хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан. Хүүхдүүдийн дунд насны ангиллаар 3х3 сагсан бөмбөг, үсэгтэлийн хаад, орен тис тэмцээнүүдийг зохион байгуулж, шалгарсан хүүхдүүдийг шагнаж урамшуулсан.	2025.01.02 2025.06.01	100
2	2025 оны цэрэг татлагын ажлыг зохион байгуулах ажлын хэсэгт ажиллах	Хариуцсан ажлыг үр дүнтэй зохион байгуулах	-	-	2025 оны ээлжит цэрэг татлагыг зохион байгуулах ажлын хэсэгт орж ажилласан.	2025.01.02 2025.04.30	100
3	Сумын орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах	Хариуцсан ажлыг үр дүнтэй зохион байгуулах	-	-	Хууль эрх зүйн мэргэжилтний хамт сумын орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний оногдуулалт дээр ажилласан.	2025.01.02 2025.02.13	100
4	Иргэдийн оролцоотой төсөв, хяналт сургалтыг зохион байгуулах	Сургалтыг үр дүнтэй зохион байгуулсан байх	-	-	Арвайхээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албатай хамтран иргэдийн орон нутгийн хөгжлийн сангийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, иргэдийг орон нутгийн хөгжлийн санд санал өгдөг болгох зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эцэг эхчүүд, асран хамгаалагчдад "Иргэдийн оролцоотой төсөв, хяналт" сэдэвт сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 29-нөөс 05 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл хугацаанд ерөнхий боловсролын 6 сургуулийн 700 гаруй эцэг эх, асран хамгаалагчдад зохион байгуулсан.	2025.01.02 2025.05.05	100
5	"Аз жаргалтай гэр бүл" вакум	Сургалтыг үр дүнтэй зохион	-	-	Аз жаргалтай гэр бүл" вакум сургалтыг зорилтот залуу гэр бүлийн дунд Насан туршийн	2025.01.02 2025.12.01	100

	сургалтыг зохион байгуулах	байгуулсан байх			суралцахуйн төвтэй хамтран зохион байгуулсан. Зорилготой өрхийн 13 хос хамрагдаж, гэр бүлийн үнэ цэнэ, хосын харилцаа, хүүхдээ хүмүүжүүлэх талаар сургалт өгч хоорондын харилцааны талаар ярилцсан. Сургалт үр дүнтэй болж цаашдаа сэтгэлзүйн сургалтыг үе шаттайгаар авч байхаар болсон.		
6	Уран бичлэг, тэргүүний уншигч шалгаруулах уралдаан зохион байгуулах	Уралдааныг үр дүнтэй зохион байгуулах	-	-	“Улс тунхагласны өдөр”-ийг тохиолдуулан тусгаар тогтнолын үнэ цэнийг таниулах, эх оронч үзэл, бахархал, үндэсний үнэт зүйлсийг ойлгуулж, үндэсний бичиг соёлоо дээдэлж, эх хэл, бичгээ хайрлан хамгаалах, суралчдын уран сэтгэмж, бичгийн соёлыг хөгжүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн суралчдын дунд уран бичлэгийн уралдааныг 2 насны ангиллаар зохион байгуулж, 8-9-р ангийн ангилалд 3, 10-12 дугаар ангийн ангилалд 10, нийт 13 суралч оролцсон. Ангилал тус бүрд эхний 3 байрыг шалгаруулж, өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсан. Ерөнхий боловсролын сургуулийн суралчдын монгол бичгийн унших чадварыг нэмэгдүүлж, эх хэл соёлдоо хайртай, уншлагын соёлтой суралчдыг дэмжих, монгол бичгээр унших, ойлгох, зөв дуудах, утгыг тайлбарлах чадварыг сайжруулах, монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, өв соёлоо түгээн дэлгэрүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн суралчдын дунд “Тэргүүний уншигч” шалгаруулах уралдааныг 2 насны ангиллаар зохион байгуулж, нийт 54 хүүхэд оролцсон. Ангилал тус бүрд эхний 3 байрыг шалгаруулж, өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсан.	2025.01.02 2025.12.01	100
7	“Хотын Хариуцлагатай иргэн” сэдвээр эсээ бичлэг, илтгэл, хэлэлцүүлэг зохион байгуулах	Уралдааныг үр дүнтэй зохион байгуулах	-	-	Ерөнхий боловсролын сургуулийн суралчдын дунд хотын соёл, иргэний хариуцлагын талаарх зөв ойлголт, төлөвшлийг бий болгох, бүтээлч сэтгэлгээ, зөв бичгийн болон өөрийн үзэл бодлоо илэрхийлэх үр чадварыг хөгжүүлэх, иргэний үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, нийгэмд зэрэг хандлага төлөвшүүлэх зорилгоор Хотын соёл-	2025.01.02 2025.12.01	100

	1	2	3	4	5	6	7
1	Отгон тэнгэр их сургуульд "Эрх зүй" - н чиглэлээр суралцаж төгсөх	Эрх зүйн бакалаврын дипломтой болох	-	Улирлын сургалтад хамрагдаж төгсөх	Отгонтэнгэр их сургуулийн эрх зүйн 2,5 жилийн ангийг амжилттай төгсөж, эрх зүйн мэргэжил эзэмшсэн.	2025.01.02 2025.06.10	100
2	Худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдах	сертификат авах	-	1	Худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдаж, АЗ сертификат авсан. Арвайхээр сумын 300 жилийн ойг угтан түүхэн баримтат кино хийх үйлгээний хорооны нарийн бичгээр ажилласан.	2025.01.02 2025.06.10	100

ТАЙЛАН ГАРГАСАН: НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН

2025 оны 11 дүгээр сарын 28

Т.ДЭЛГЭРМАА

НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН
Т.ДЭЛГЭРМААГИЙН 2025 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр: Нийгмийн бодлого

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, Политехник коллежийн сурагчдын сурлагын амжилт, гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг дээшлүүлнэ.					
1.	Арга хэмжээ 1.1.	60	10	70	70
2.	Арга хэмжээ 1.2.	60	10	70	70
3.	Арга хэмжээ 1.3	60	10	70	70
Зорилт 2.Боловсролын байгууллагын барилга, байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан, тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлж, цэцэрлэг, сургуулийн анги, бүлэг дүүргэлтийг багасгана.					
4.	Арга хэмжээ 2.1.	45	10	55	55
5.	Арга хэмжээ 2.2.	60	10	70	70
6.	Арга хэмжээ 2.3.	60	10	70	70
Зорилт 3. “Хотын соёл хөтөлбөрийг хэрэгжүүлэх”					
7.	Арга хэмжээ 3.1.	30	10	40	40
Зорилт 4. “Ахмад настнуудын эрэлт хэрэгцээнд суурилсан үйл ажиллагааг зохион байгуулж, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх”					
8.	Арга хэмжээ 4.1.	60	10	70	70
9.	Арга хэмжээ 4.2.	60	10	70	70
Зорилт 5. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах”					
10.	Арга хэмжээ 5.1.	60	10	70	70
11.	Арга хэмжээ 5.2.1	60	10	70	70
12.	Арга хэмжээ 5.2.2	60	10	70	70
13.	Арга хэмжээ 5.3.	60	10	70	70
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.	60	10	70	70
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.	60	10	70	70
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.	60	10	70	70
4.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4.	60	10	70	70

5	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5.	60	10	70	70
6	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6.	60	10	70	70
7	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7.	60	5	65	65
Дундаж оноо:				67.5	67,5

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1.	100	15	15
2.	Арга хэмжээ 2.	100	15	15
Дундаж оноо			15	15

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	7
2.	Дүн шинжилгээ хийх	7	7
3.	Асуудал шийдвэрлэх	7	7
4.	Хариуцлагатай байдал	7	7
5.	Ажлын цаг ашиглалт	7	7
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.	7	7
7.	Мэргэжлийн ур чадвар 2.	7	7
8.	Мэргэжлийн ур чадвар 3.	7	7
Дундаж оноо		7	7

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	7, 82
2.	Багаар ажиллах	7, 91
3.	Харилцаа	7, 91
Дундаж оноо		7, 88

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	67,5
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	7

4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	7,88
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		97,3.

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Төрийн жинхэнэ албан хаагч:

НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН

Т.ДЭЛГЭРМАА

2025 оны 11 дүгээр сарын 28

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

1. Хамт олны дарга



Төрийн жинхэнэ албан хаагч

2025 оны дүгээр сарын

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

1024016041
98441132-Б СБГ24391

2025 оны дүгээр сарын

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

С.ГАНЧИМЭГ

2025 оны дүгээр сарын